



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.29 № 01/23 ЧАТ-САТ/2014/09/СТНА-ТРЕС

Төсвийн орлого болгох тухай

Хөдөлмөрийн сайдын 2013 оны төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөрийн яамны харьяа БНСУ дахь Нэг цэгийн үйлчилгээний төвийн вонын харилцах дансанд 30.8 сая төгрөг /19.3 сая вон/, бэлэн мөнгөний кассад 7.3 сая төгрөг /5.4 сая вон/, нийт 38.1 сая төгрөгийн /24.7 сая вон/ үлдэгдэл байршиж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.7-д "...төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д: "...аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих ...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 2.1.1-т "төлбөл зохих төсвийн орлогыг дутуу төвлөрүүлсэн болон төвлөрүүлээгүй"-д төлбөрийн акт тогтооно гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус төвийн вонын харилцах болон кассын дансны үлдэгдэл 38.1 сая төгрөгийг 2014 оны 6 дугаар сарын 30-ны дотор Төв төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Улсын төсвийн орлогын 900000601 дүгээр дансанд татан төвлөрүүлэх
2. Төлбөрийн акт барагдуулах арга хэмжээ авч, биелэлтийг 2014 оны 07 дугаар сарын 1-ний дотор УАГ-т ирүүлэхийг Хөдөлмөрийн яамны харьяа БНСУ дахь Нэг цэгийн үйлчилгээний төвийн дарга М.Нямдаваа, нягтлан бодогч Л.Оюунсүвд нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:

Үндэсний аудитын газрын  
Аудитор

УХА0122

П.Чанцалдулам

ЗӨВШӨӨРСӨН:

НЦҮТ-ийн Дарга

М.Нямдаваа